

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/004/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: О.Энхтөр Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 15 № 110

танай _____ -ны № _____ -т

ИННОВАЦ СУДАЛГАА, БИЗНЕС
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ё.НАРАНГАРАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Инновцаи судалгаа, бизнес хөгжлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.3, 20.1.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд төлөвлөгдөөгүй 46,031.0 мянган төгрөгийг зарцуулсан ба 8,704.5 мянган төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлсэн 26,501.7 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоор тайлагнаж үүнээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны тайлан, сэтгүүл хэвлүүлэхэд 12,000.0 мянган төгрөг, аймгийн баяр наадмын хөгжим, техник хэрэгслийн түрээсийн зардалд 10,250.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний нийт зардлыг 4,382.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

8225920311

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн брэнд бүтээгдэхүүний хаяг, шошгод тавигдах чанар стандартын шаардлагыг боловсруулах төслийг хэрэгжүүлж байна.

Тайлант онд Бурхан буудай хайрхан уулын тэнгэрийг тайх Төрийн тахилгын ёслол, Жангар фестиваль-3, “Хантайшир экспо-Үржлийн шилмэл мал 2024” үзэсгэлэн худалдаа, “Хүргэлт-5” арган хэмжээнд тус тус оролцсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Тайлант онд 12,000.0 мянган төгрөгөөр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны тайлан, сэтгүүл хэвлүүлсэн, 10,250.0 мянган төгрөгөөр аймгийн баяр наадмын хөгжим, техник тоног төхөөрөмжийг түрээсэлсэн, 4,000.0 мянган төгрөгөөр хэвлэлийн эх, видео бичлэг хийлгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 8 зорилт, 35 арга хэмжээний хэрэгжилтийг 92.9 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,672,548.15	26,444,688.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,440,854.59	19,780,597.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,440,854.59	19,780,597.37
3121	Төгрөг	7,440,854.59	19,780,597.37
31213	Арилжааны банк дахь харилцах	7,440,854.59	19,780,597.37
33	АВЛАГА	1,980,628.56	1,980,626.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,980,626.00	1,980,626.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,251,065.00	4,683,465.00
351	Түүхий эд материал	305,000.00	305,000.00
35110	Тусгай зориулалттай материал	305,000.00	305,000.00
354	Хангамжийн материал	3,946,065.00	4,378,465.00
35420	Аж ахуйн материал	2,600,400.00	3,132,800.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,665.00	1,245,665.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	48,235,421.70	33,637,556.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	48,235,421.70	33,637,556.71
392	Биет хөрөнгө	38,356,755.13	27,582,890.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,021,000.00	45,021,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,288,292.10)	(27,998,192.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,668,800.00	13,108,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,161,419.35)	(4,565,284.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,500,000.00	5,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,383,333.42)	(3,483,333.46)
393	Биет бус хөрөнгө	9,878,666.57	6,054,666.53
39301	Програм хангамж	19,120,000.00	19,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,241,333.43)	(13,065,333.47)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	61,907,969.85	60,082,245.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	391,597.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	391,597.00
413	Өглөг	(0.00)	391,597.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	282,221.00
4136	Бусад өглөг	(0.00)	109,376.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	109,376.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	61,907,969.85	59,690,648.08
51	Засгийн газрын хувь оролцоо	61,907,969.85	59,690,648.08
512	Хуримтлагдсан үр дүн	61,907,969.85	59,690,648.08
51210	Өмнөх үеийн үр дүн	128,212,649.97	61,907,969.85
51220	Тайлант үеийн үр дүн	(66,304,680.12)	(2,217,321.77)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	61,907,969.85	60,082,245.08

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	277,452,172.37	341,306,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,298,600.00	341,306,700.00
1330	Төсвийн захирагчдаас	245,298,600.00	341,306,700.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	245,298,600.00	341,306,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	343,756,852.49	343,524,021.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,756,852.49	343,524,021.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,756,852.49	343,524,021.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,756,852.49	343,524,021.77
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	71,278,792.64	52,436,006.77
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	218,667,248.48	237,485,983.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	53,810,811.37	53,602,032.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-66,304,680.12	-2,217,321.77
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-66,304,680.12	-2,217,321.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	277,452,172.37	341,306,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	245,298,600.00	341,306,700.00
1330	Төсвийн захирагчдаас	245,298,600.00	341,306,700.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	245,298,600.00	341,306,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	330,374,602.41	328,966,957.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	330,374,602.41	328,966,957.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,374,602.41	328,966,957.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,717,095.04	235,451,498.00
210106	Ажилдагчдад төлсөн /ТӨҮГ/	188,717,095.04	235,451,498.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,020,156.00	29,009,667.22
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	23,020,156.00	29,009,667.22
2104	Хангамж, бараа материалын зардал	49,611,306.00	9,263,760.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	49,611,306.00	9,263,760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,026,045.37	55,242,032.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,026,045.37	55,242,032.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-52,922,430.04	12,339,742.78

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-54,922,430.04	12,339,742.78
------	--	----------------	---------------

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	128,212,649.97	128,212,649.97
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	128,212,649.97	128,212,649.97
9	Тайлант үеийн үр дүн	(66,304,680.12)	(66,304,680.12)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,907,969.85	61,907,969.85
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	61,907,969.85	61,907,969.85
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,907,969.85	61,907,969.85
19	Тайлант үеийн үр дүн	(2,217,321.77)	(2,217,321.77)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	59,690,648.08	59,690,648.08

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төсвөөс санхүүжих орлого	336,910,000.00	341,306,700.00	(4,396,700.00)	101%
ОРЛОГО	336,910,000.00	341,306,700.00	(4,396,700.00)	101%
1.3 Нийт ашиг	336,910,000.00	341,306,700.00	(4,396,700.00)	101%
Цалин	267,300,000.00	235,845,983.00	31,454,017.00	88%
Байгууллага төлөх НДШ	33,412,500.00	29,006,781.78	4,405,718.22	87%
Бичиг хэрэг	3,485,000.00	1,678,650.00	1,806,350.00	48%
Шуудан холбоо	4,200,000.00	1,053,100.00	3,146,900.00	25%
Томилолт	6,866,000.00	1,640,000.00	5,226,000.00	24%
Шатахуун	4,200,000.00	1,027,400.00	3,172,600.00	24%
Түрээсийн төлбөр	9,600,000.00	-	9,600,000.00	0%
Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	2,400,000.00	4,837,560.00	(2,437,560.00)	202%
Урсгал засвар	-	1,000,000.00	(1,000,000.00)	0%
БГАҮ	-	46,031,032.00	(46,031,032.00)	0%
Бараа үйлчилгээний зардал	3,746,500.00	14,971,779.96	(11,225,279.96)	400%
Хичээл үйлдвэрлэл	1,700,000.00	-	1,700,000.00	0%
Хангамжийн материал	14,285,000.00	8,596,710.00	5,688,290.00	60%

1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	351,195,000.00	345,688,996.74	5,506,003.26	98%
------------------------------------	----------------	----------------	--------------	-----

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 26,941.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Аймгийн Засаг даргын Тамгын газраас хуваарилсан 26,501.7 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогод тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- Тайлант онд 439.9 мянган төгрөгийн хөргөгч худалдан авсан боловч орлого аваагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; гэж заасныг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 69,367.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 69,367.7 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас анхан шатны баримтгүй 8,704.5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"-тай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөсөн зардлыг 4,382.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах; "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт /үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах/"-тай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулах зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал төлөвлөөгүй байхад 46,031.0 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний дагуу зардлыг зарцуулах зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Аймгийн баяр наадмын хөгжим, техник хэрэгслийн түрээсийн зардалд 10,250.0 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Санхүү хяналт, дотоод аудитын албанд хяналт хийх албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж			
		Тоо		Тоо		Тоо		Тоо		Залруулсан		Залруула агүй		Тоо	
		Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14		
Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв	Аймгийн Засаг даргын Тамгын газраас хуваарилсан 26,501.7 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогод тайлагнасан.	1	26,051.7	-	-	1	26,051.7	1	26,051.7	-	-	-	-		
	Тайлант онд 439.9 мянган төгрөгийн хөргөгч худалдан авсан боловч орлого аваагүй байна.	1	439.9	-	-	1	439.9	1	439.9	-	-	-	-		
	Дүн	2	26,941.6	-	-	2	26,941.6	2	26,941.6	-	-	-	-		

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас анхан шатны баримтгүй 8,704.5 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.	1	8,704.5	-	-	1	8,704.5	-	-	-	-		
Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв	Байгууллагын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөсөн зардлыг 4,382.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна	1	4,382.2	-	-	1	4,382.2	-	-	-	-		

Говь-Алтай аймаг дахь Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал төлөвлөөгүй байхад 46,031.0 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	46,031.0	-	-	1	46,031.0	-	-	-
	Аймгийн баяр наадмын хөгжим, техник хэрэгслийн түрээсийн зардалд 10,250.0 мянган төгрөгийг төлсөн байна.	1	10,250.0	-	-	1	10,250.0	-	-	-
Нийт		4	69,367.7	-	-	4	69,367.7	-	-	-